

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2023 оны жилийн эцсийн байдлаар/

Орхон аймаг. Эрүүл мэндийн газар

2023.12.04

№	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүн		Хэрэгжилтийн хувь
							2023 он	Хүрсэн түвшин, үр дүн	
1		2	3	4	5	6	7	8	9
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО									
1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.									
1	1.1.1.“Ковид-19” халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	5	Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйтгэлийн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2021	ХОХБТХ,		Мэдээлэл сурталчилгааг тогтмол хийж, сургалт зохион байгуулна.	Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг иргэдэд төлөвлөлтийн дагуу орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон цахимаар тогтмол хүргэн ажилласан. Тайлант хугацаанд 20 төрлийн гарын авлага, зөвлөмжийг байршуулан 15720 иргэнд түгээн ажилласан. Коронавируст халдварын орон нутгийн нөхцөл байдлын мэдээлэл 25 удаа хийсэн. Цахим хэлбэрээр хийгдсэн мэдээлэл, сургалтад хамрагдсан хүний хувь 14,8% байна.	70
2	1.1.2.“Ковид-19” халдварт цар тахлын	4	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын	2020-2021	НБХ		Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80%-аас	Томуугийн вакцины хамралт 8140 хамрагдахаас 7601 хамрагдаж, хамралт 93.4%, үүнээс 2-5 насны хүүхэд 76.3%, жирэмсэн 25.1%, эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад 101.3%-тай	94,2

	эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг		томуугийн вакцинд бүрэн хамруулна.				доошгүй улирлын томуугийн вакцинжуулалтад бүрэн хамруулсан байна.	байна. Архаг хууч, 65-аас дээш насны иргэдийн хамралт 400 хамрагдахаас 1727 тус тус хамрагдаад байна. Томуугийн эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэхээр: - 4 төрлийн зурагт хуудсыг цахим орчинд 5924 иргэнд түгээсэн байна. - Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 30 эрхлэгчид томуугийн эсрэг дархлаажуулалтын талаар мэдээлэл хүргэсэн.	
3	нэмэгдүүлнэ:	6	Хүн амыг коронавируст халдварын эсрэг вакцинд хамруулна.	2020-2021	НБХ		Хүн ам коронавируст халдварын эсрэг вакцинд хамрагдсан байна	Тайлант хугацаанд коронавируст халдварын 1-р тунд 9, 2-р тунд 13, 3-р тунд 23, 4-р тунд 18, 5-р тунд 6 иргэн тус тус хамрагдаж нийт 69 хүн тун вакцин хийгдсэн байна. Дархлаажуулалтын дараах хариу урвал бүртгэгдээгүй байна.	70
4	1.1.3.Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	3	Шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулна	2021-2024	НБХ		Төлөвлөгөөт сургалт сурталчилгаа бүрэн хийгдсэн байна.	Шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэх талаар 46 төрлийн гарын авлага, зөвлөмжийг байршуулан 17839 иргэнд түгээн ажилласан. Аймгийн Улаан загалмайн хороо, Боловсрол шинжлэх ухааны газар, Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран 376 хүнд улаанбурхан өвчин, товлолт вакцины чиглэлээр сургалт зохион байгууллаа. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн туршлага, сургамж" сэдвээр цахим сургалтад 15 албан хаагч, "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн туршлага, сургамж" эрдэм шинжилгээний хуралд 5 мэргэжилтэн хамрагдсан. Гахайн хавдар MRSA өвчний талаарх сургалтыг мэдээллийг нийт 105 хүнд хүргэсэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэх 20 удаагийн зөвлөмж мэдээлэл хийгдсэн.	90
5		7	Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний	2021-2024	НБХ		5 аймгийн НЭ, БОЭТ -д БХ-ПГУ төхөөрөмжтэй	Вируслогийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж орон нутгийн төсвөөс лабораторийн тоног төхөөрөмжид 297.0 сая, лабораторийн байрны засвар, тохижилтод 57 сая нийт 354.0	100

			төвүүдийн Молекул биологийн лабораторийн чадавхыг бэхжүүлнэ.				болж, лабораторийн чадавх нэмэгдсэн байна.	сая төгрөгийг шийдэн Нийгмийн эрүүл мэндийн төвд вируслогийн лабораторийг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас Эмнэлэг сувиллыг түшиглэн 470.0 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж, урвалж оношлуураар ханган шинээр вируслогийн лабораторийг 2021 онд шинээр байгуулсан. Тайлант хугацаанд Бх-ПГУ шинжилгээг 988 иргэнд хийхэд коронавируст халдвар (КОВИД-19) 1 тохиолдол батлагдсан байна.		
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО										
2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.										
6	2.1.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын	1	"Эрүүл, идэвхтэй амьдрал" арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ		Арга хэмжээний хэрэгжилт 50%	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, дасгал хөдөлгөөний сурталчлах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Үүнд: - Тайлант хугацаанд 20 удаагийн өдөрлөг, аян, 110 удаагийн сургалтад 7750 иргэнийг хамруулж, 50 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн телевизүүдтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн байна. - Цахим хуудаст 108 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 211168 иргэнийг мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр хангасан. - Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж 4 удаагийн явган алхалт зохион байгуулж нийт 923 хүнийг хамруулсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 84.8%-тай байна.	100	
7	нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын	2	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ	ОНТ 8.0	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувь	2023 оны байдлаар халдварт өвчний 972 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 91,5 ногдож, өмнөх оны мөн үеийнхээс 357,8 промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 53.9%-ийг амьсгалын замын халдварт	100	

	<p>хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрдийг хэрэгжүүлнэ.</p>					<p>өвчин, 13.8%-ийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 4.8%-ийг гэдэсний халдварт өвчин, 0,6%-ийг зоонозын халдварт өвчин, 0.7%-ийг цусаар дамжих халдвар тус тус эзэлж байна. Дархлаажуулалтын хамралт 99,75%-тай байна. Тархвар судлалын заалтаар (Ковид-19)-ийн вакцинд 69, Хачигт энцефалитын вакцинд 533 иргэн, хачигт энцефалитийн ийлдэс эмчилгээнд 6 иргэн, галзуугийн вакцинд 237, галзуугийн ийлдэс эмчилгээнд 9 хүнийг тус тус хамруулсан. Дархлаажуулалт бүхий халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй. Томуугийн ажлын хэсэг 6 удаа хуралдаж, 18 шийдвэр гарган, эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл, Боловсрол шинжлэх ухааны газарт зөвлөмж хүргүүлж, 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв зэрэг 11 байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийж зөвлөмжөөр хангасан. Эрүүл мэндийн байгууллагуудын цагаан хэрэгслээр хангасан тухай мэдээлэл, угаалгын газрын үйл ажиллагаанд үнэлгээ хийгдсэн. Монголын тархвар, халдвар судлагч эмч нарын нийгэмлэгтэй хамтран орон нутгийн 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр 47 халдвар хяналтын ажилтныг бэлтгэж гэрчилгээ олгосон. Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 5,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8 промиллоор нэмэгдэж, бэлгийн замаар дамжих халдвар 10 000 хүн амд 12,7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,8 промиллоор буурсан байна.</p> <p>Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ /2022-2025 он/-г хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 90,7%-тай байна.</p>	
--	---	--	--	--	--	--	--

8		3	"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ	ОНТ 20.0	Арга хэмжээний хэрэгжилт 50 хувь	<p>"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуурын хэрэгжилт 88.5 хувьтай байна.</p> <p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 4 албан тоот, 1 албан даалгавар, 6 мэдээллийг хүргүүлэн хяналт хийн зөвлөмж өгсөн. - Томуу, томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн үед 150-200 ор нэмэлтээр дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалтаар өрхийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулж тусламж үйлчилгээний ачааллыг бууруулсан. - Эх хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний стандарт, чанар хүртээмжид 2 удаа үнэлгээ хийн зөвлөмжөөр хангасан. - Эрт илрүүлэг үзлэгт 0-17 насны хүүхдийн 74,5 хувь нь хамрагдаж улсын хэмжээнд тэргүүлсэн. - Тайлант хугацаанд бүртгэгдсэн амьгүй болон гэрийн төрөлт, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн нийт 29 тохиолдолд үзүүлсэн тусламж үйлчилгээг Эмчилгээ чанарын албад, Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөмж өгч ажилласан. - ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭМГ-аас зохион байгуулсан сургалтаар давхардсан тоогоор нийт 305 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. - Хүүхдийн эрхийг хамгаалах хороо 2 удаагийн хурлаар эрх нь зөрчигдсэн 2 кейсийг хэлэлцэж, СЭТҮТ-д өсвөр насны 1 хүүхдийг илгээн түр хамгаалах байранд 2 хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлсэн. - Жирэмсний эрт үеийн хяналт 98.3 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,8 хувиар нэмэгдсэн. - 2079 эх амаржсанаас 16-19 насны 52 буюу 1000 эмэгтэйд ногдох охидын төрөлт 15.8 	100
---	--	---	---	-----------	-----	-------------	----------------------------------	--	-----

								<p>промилл болж өмнөх оны мөн үеэс 3.4 промиллоор буурсан.</p> <ul style="list-style-type: none"> - Нялхсын эндэгдлийн 17 тохиолдол буюу 8,2 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,9 промиллээр нэмэгдсэн, - Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хангалт 75.8 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар нэмэгдсэн. - Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдийн 22 хувь нь үзлэгт хамрагдсан байна. 	
9		4	“Хавдрын эсрэг” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2020-2024	НБХ	ОНТ 43.2	Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хүрэх түвшин 60 хувьд хүргэнэ.	<p>Тайлант хугацаанд хорт хавдрын 212 тохиолдол шинээр бүртгэгдэж 10 000 хүн амд 20.0 промилл, өмнөх оны мөн үеэс 2.9 промиллоор нэмэгдсэн. Шинээр бүртгэгдсэн хорт хавдраас 30.2%-ийг элэгний хавдар, 18.4%-ийг ходоодны хавдар, 7.1%-ийг умайн хүзүүний өмөн, 44,3%-ийг бусад хавдар эзэлж байна. Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 82,7%-тай байна.</p> <ul style="list-style-type: none"> - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2931 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 105.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (79.2) хувиар өссөн. Пап шинжилгээнд нийт 1215 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 16527 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 87,4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (50,6) хувиар өссөн байна. - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 887 хүн буюу (54.8) хувь нь хамрагдсан. <p>Хавдрын хими эмчилгээнд 251 хүн хамрагдаж өмнөх оны мөн үеэс 39 тохиолдлоор бага байна. Хөнгөвчлөх эмчилгээний тасгаар хорт хавдартай 164 иргэн үйлчлүүлсэн байна. Бай эмчилгээг 2023 оны 04 сараас орон нутагтаа нэвтрүүлж 58 иргэнд тусламж үйлчилгээг</p>	100

							<p><u>үзүүлсэн.</u> Хавдрын /Улаан хоолой, ходоод/ салст хуулах хагалгааг нутагшуулан тайлант хугацаанд 11 иргэнийг эмчлэн эрүүлжүүлсэн. Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс тайлант хугацаанд 109 иргэнд 43,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Тайлант хугацаанд хавдрын 159 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 69,2 хувь нь хамрагдсан байна. Хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр 17 төрлийн сургалтад 11247 иргэнийг хамруулж, 43 төрлийн сурталчилгааны материалыг цахимд байршуулахын зэрэгцээ 34739 иргэнд түгээсэн байна.</p> <p>“Хавдрын эсрэг” арга хэмжээний хэрэгжилт 80,2%-тай байна.</p>	
10		5	“Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүргэнэ	<p>Тайлант хугацаанд элэгний В вирус илрүүлэх шинжилгээнд 3620 иргэн хамрагдсанаас 120 хүн буюу 3.3%, С вирус илрүүлэх шинжилгээнд 3610 иргэн хамрагдсанаас 121 буюу 3.4% нь эерэг илэрч 65 хүн эмчилгээнд хамрагдсан. Нярайн төрсний дараа 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.7 хувь, 2 настай хүүхдийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 100 хувьтай байна. В вирусийн эсрэг тархвар судлалын заалтаар дархлаажуулалтад 1522 иргэн хамрагдсан. Элэгний В, С вирусээс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг таниулах 7 төрлийн зурагт хуудсыг цахимаар 8081 хүнд түгээж, 88 хүнийг сургалтад хамруулсан байна.</p> <p>Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын 231 эмч буюу нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 26.4 хувийг хамруулсан байна.</p>	100

							Тайлант хугацаанд вирус гепатитын 6 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.6 промилл байна. Тайлант хугацаанд элэгний хорт хавдрын нас баралт 45 тохиолдол 10000 хүн амд 4.2 промилл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 промилл буурсан, элэгний хатуурлын нас баралт 11 тохиолдол 10000 хүн амд 1.0 промилл өмнөх оны мөн үеэс 0.1 промилл буурсан. Тайлант хугацаанд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хэрэгжилт 85.8 хувьтай байна.		
11		6	“Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ	ОНТ 331.8	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүргэнэ	Тайлант хугацаанд: -Харшлаас сэргийлэх арга хэмжээг төлөвлөх салбар дундын уулзалтыг 1 удаа зохион байгуулж төлөвлөгөөг батлуулсан. -Арьс, харшлын тусламж үйлчилгээг 12554 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,5%-р өссөн үзүүлэлттэй байна. -Харшлын шалтгаант өвчлөлийн оношилгоо, эмчилгээний менежментийг сайжруулах чиглэлээр сургалтад 80 эмчийг хамруулсан. -Аймгийн хэмжээнд 30 эрүүл мэндийн байгууллагад харшлын тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж хэрэгжилт 90%-тай байна. -Арьс харшлын эмчийн мэргэшүүлэх сургалтад төрийн сангийн санхүүжилтээр 1 их эмч суралцаж байна. -Хотын ногоон байгууламж бүхий гудамж талбайд таригдсан 849 ширхэг улиас модонд тоосжилт, үр хаялтыг бууруулах зорилгоор залуужуулах, хэлбэржүүлэх тайралт, таналтыг хийсэн. Орон нутгийн хөрөнгө 331.8 сая төгрөгийн оруулалтаар Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж нэмэгдүүлэх чиглэлээр 2 төрлийн зүлэгжүүлэлтийн ажлыг 11300 м2 талбайд хийж гүйцэтгэсэн.	100

							<p>-Харшлаас сэргийлэх зорилгоор 2 удаагийн сургалтад сургууль цэцэрлэгийн эмч, хоол зүйч 98 хүн, эрүүл мэндийн 110 багшид сургалт зохион байгуулж, цахим хуудсаар дамжуулан “Хүнсний бүтээгдэхүүний шошго уншиж сурцгаая” гарын авлагыг 8765 иргэнд түгээж хүргэсэн. Номин телевизийн “Хүнсний аюулгүй байдлын цаг” тусгай хөтөлбөрт “Хүнсний бүтээгдэхүүний шошго унших, сонголт”-ын талаар мэдээлэл хүргэсэн. Амьтны харшлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж хэвлүүлж, мал эмнэлэг, малын эмийн сан болон амьтны дэлгүүр болох 8 байгууллагад байршуулж, цахим хуудсуудаар иргэдэд хүргэсэн.</p> <p>-Аймгийн хэмжээнд харшлын шалтгаант амьсгалын замын архаг өвчлөлөөс бронхийн багтраа 10,000 хүн амд 11,4 промилл, бронхит 10,000 хүн амд 6,9 промилл байна.</p> <p>Харшлаас сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт 93,5%-тай байна.</p>	
12	7	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ	БОЭТ гүйцэтгэлийн санхүүжилт 112.0	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүргэнэ	<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эрчүүдийн кабинетыг орон нутагт анх удаа байгуулан хүний нөөц, байр, багаж тоног төхөөрөмжийг үе шаттай ханган үйл ажиллагаа нь жигдэрч, улсын хэмжээнд сайн туршлага болсон. Тус кабинет нь 18м.кв үзлэгийн өрөө, 12м.кв ажилбарын өрөөтэй бөгөөд эрэгтэйчүүдийн бөөр шээсний замын болон нөхөн үржихүйн эрхтний эмгэгийн оношилгоо, эмчилгээ зэрэг 10 төрлийн багцын тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. Тус кабинет нь эрэгтэйчүүдийн 1 эмч, эмнэлгийн 1 мэргэжилтний орон тоотой ажиллаж тайлант хугацаанд 1526 үзлэг хийгдсэнээс өвчлөлийн 625 тохиолдол бүртгэгдэн эмчлэгдэж, 32 эрэгтэйг лавлагаа шатлалд илгээсэн байна. Тайлант хугацаанд 7 ерөнхий боловсролын сургуулийн 952 өсвөр үе, хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр 4 удаагийн сургалт, эрэгтэйчүүд олноор ажилладаг 5 байгууллагын</p>	100

							<p>1100 гаруй эрэгтэйд эрүүл мэнд, эрсдэлт хүчин зүйлсийн талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр 2 төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн газраас “Ний нуугүй ярья” төслийн хүрээнд 800 хүүхдэд бэлгийн замын халдварт өвчин, нөхөн үржихүйн эрүүл мэнд, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаанд хамруулсан. - Ариунсаруулбат НҮТББ нь “Сэтгэцийн эрүүл мэндийг хүн бүрт” төслийг амжилттай хэрэгжүүлэн 7 сургууль, МСҮТ-ийн 765 өсвөр үе, эрэгтэй хүүхдэд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаанд хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. <p>“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 87,75%-тай байна.</p>	
13	<p>2.1.2. “Элэг бүтэн Монгол арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын</p>	2	<p>Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна</p>	2021-2024	НБХ	<p>УТ 50.0</p> <p>Эмчилгээнд хамрагдах хувийг 40 хувьд хүргэнэ.</p>	<p>Орхон аймгийн хэмжээнд Д вирустэй оношлогдсон 290 иргэний судалгаа гарган анхан болон лавлагаа шатлалын эмчийн идэвхтэй хяналтад хянагдаж байгаа ба хавдрын илрүүлэг шинжилгээнд улирал тутамд хамруулан ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/362, гепатитын В,Д вирустэй халдвартай иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” А/363 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 50 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны төлөвлөлт хийгдэн эхлүүлээд байна.</p>	50

	жишигт хүргэнэ.								
14	2.1.4.Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.	2	Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.	2021-2024	НБХ	БОЭТ гүйцэтгэлийн санхүүжилт 45.0	Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхэжсэн байна.	<p>Яаралтай тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд хүний нөөцийн чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт яаралтай тусламжийн сувилахуйн чиглэлээр 3 сувилагч суралцаж төгссөн, намрын элсэлтээр 4 сувилагч суралцаж байна. - Хувийн хэвшлийн 7 эмнэлэг яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг ажиллуулж байна. - Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд БОЭТ-ийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран 6 удаагийн сургалтад 45 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. - Амилуулах суурь тусламжийг сайжруулах хүрээнд ажил мэргэжлийн уралдааныг Монголын Яаралтай тусламжийн Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 14 багийн 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, орчин үеийн технологи Kahoot, Quiz maker программыг анх удаа ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гардан болон онолын мэдлэгийг нэмэгдүүлсэн. Мөн амилуулах суурь тусламжийн сургалтад нийт 121 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, чадавхжууллаа. <p>Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - БОЭТ-ийн Төрөх тасгийн хүлээн авах тасагт SAMSUNG ЭХО аппаратын датчикийг байгууллагын 45 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэж оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн. - Яаралтай түргэн тусламжийн тасагт шархны анхдагч цэгцлэлтийн багажаар хангасан. - Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай 	100

								тусламж үзүүлэх тоног төхөөрөмжийн хангалт 95%-д хүрсэн. Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх, мэргэшсэн хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оноос 5 хувиар нэмэгдэж 90 хувьд хүргэсэн.	
15		4	Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.	2021-2024	НБХ	ОНТ 285.0	150 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна.	Аймгийн хэмжээнд БОЭТ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасгийн 11 машин дуудлагад үйлчилж байна. Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгаас 285 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Түргэн тусламжийн үйл ажиллагаанд 2 удаа хяналт хийж, зөвлөмжөөр ханган ажилласан. Эрдэнэт клиник болон Эрдэнэт сувилал яаралтай тусламжийн "Бид бэлэн" аяныг зохион байгуулж, нийт 70 ажилтныг хамруулсан байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 12208 дуудлагад үйлчилснээс яаралтай тусламжийн дуудлага 4764 буюу 39%-ийг, алсын дуудлага 37 буюу 0,7%-ийг эзэлж байна. Яаралтай тусламжийн дуудлагад 20 минутын дотор очсон хувь 100% байна.	100
16	2.1.5.Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно.	1	Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулна.	2021-2024	НБХ, ЭМГ		2 дүүрэг, 6 аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн дэмжих төв байгуулна	БОЭТ-ийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төв нь нийт 320 м2 талбай бүхий стандартын шаардлага хангасан байранд үйлчлүүлэгчдэд эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус төв нь байгуулагдсанаас хойш нийт 8672 иргэнийг эрт илрүүлэгт үзлэгт хамруулснаас ходоод, улаан хоолойн 33 хавдар оношлогдсоны 60,6 хувийг эрт үед нь илрүүлэн орон нутагт ходоодны салст хуулах хагалгаанд 11, Хавдар судлалын үндэсний төвд 22 тохиолдлыг илгээсэн үзүүлэлттэй байна. 2023 онд 4 насны багцаар 7052 хүнийг хамруулснаас 4540 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 1612 буюу 35.5 хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин, 1040 буюу 20.9 хувь нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 181	100

								буюу 3.9 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 1344 буюу 29.6 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 63 буюу 1.3 хувь нь амьсгалын тогтолцооны өвчлөл бүртгэгдэж, нийт тохиолдлын 91.2 хувийг эзэлж байна.	
17		3	Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	НБХ	Эрүүл мэндийг дэмжих сан 29.5 ОНТ 29.0	Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулна.	Тайлант хугацаанд нийт 131 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 28288 иргэнийг хамруулж, 80 төрлийн сурталчилгааны материалыг 2500 иргэнд түгээсэн. Цахим хуудаст 644 төрлийн гарын авлага, шторка, зөвлөмжийг байршуулан 1588230 хандалттай байна. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар нийт 107 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 4 төслийг хэрэгжүүлэн ажилласан. - Эрүүл мэндийг дэмжих сангаас 13.5 сая төгрөгийн “Ний нуугүй ярь” төсөл, 16.0 сая төгрөгийн “Сэтгэцийн эрүүл мэндийг хүн бүрт” төсөл хэрэгжүүлж, 1000 хүнд бэлгийн эрүүл мэндийн боловсрол олгож, 3000 гаруй хүнд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгож хүрч ажилласан байна. - Орон нутгийн 29.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Энэ жилдээ эрүүл жиндээ” төслийг хэрэгжүүлж, төрийн 10 байгууллагын 60 хүн хамрагдан, төслийн хүрээнд нийт оролцогчид 93,4 кг жин хаясан. - “Зөвийг дадал болгоё” төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 4-5 дугаар ангийн 2100 сурагч, 500 иргэнийг шүд угаах сургалтад хамруулан, мэдлэг, дадал олгон, шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагт анх удаа зохион байгуулсан.	90
18		7	Нийгмийн эрүүл	2021-	НБХ		8 аймаг, 4	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны	100

			мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.	2024			дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна.	А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтцэд Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулж, 10 эмч, эмнэлгийн мэргэжилтний орон тоотойгоор аймгийн хүн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Тус төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн нэгж болох Хоол шим тэжээлийн кабинет, чийрэгжүүлэлт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх кабинет, 2 сургалтын танхим, хэвлэл мэдээллийн студи, дархлаажуулалтын хүйтэн хэлхээ зэргийг ажиллуулж байна. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвд 1 мэргэжилтэн шинээр ажилд авч хангалтыг нэмэгдүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2 мэргэжилтэн АШУУИС-ийн мэргэжил дээшлүүлэх институтэд 6 сарын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. Тайлант хугацаанд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр зайн болон танхимын сургалтад 190 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдлаа. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 38 дугаар тушаалыг үндэслэн Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц орон тоог нэмэгдүүлэх, бие даасан нэгж болгох болон тус төвийн санхүүжилтийн төслийг ЭМЯ-нд хүргүүлсэн.	
19	2.1.6.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо,	4	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2021-2023	НБХ		Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 31 эрүүл мэндийн байгууллагад телемедицин нэвтэрсэн байна.	Тайлант хугацаанд телемедицин хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: - БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар тус их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төвийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр байгуулсан. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн.	100

	эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.							- Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд 4 өвчтөний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж лавлагаа шатлалын эмнэлгүүдээс оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан байна. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалт 33,2%-тай байна.	
20		7	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ.	2021-2023	НБХ		Нийт 191 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн байна.	Алслагдсан сум, багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон Мөнхсүндрэл, Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж үйлчилгээ нэвтэрсэн байна. Жаргалант сумын алслагдсан өрхийн иргэд, Баян-Өндөр сумын 10 чиглэлд оторлож буй малчдад болон явуулын тусламж үйлчилгээгээр 1246 иргэнд Мобайл тусламж үйлчилгээг үзүүлснээс ахмад настан 514, 0-5 насны хүүхэд 225, жирэмсэн 307, хөгжлийн бэрхшээлтэй 64 иргэн тус тус хамрагдсан байна.	90
21	2.1.7.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг	4	Эмнэлгийн хагас бие даасан байдлыг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлнэ.	2020-2024	НБХ			БООТ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд 1 эмч,1 сувилагч, 1 тусгай мэргэжилтнийг сонгон шалгаруулсан бөгөөд ЭМС-ын 2020 оны А/563 дугаар тушаалын дагуу олон нийтийн төлөөллийн мэргэжлийн нийгэмлэг 1, төрийн бус байгууллагын 1 төлөөллийг ЭМЯ-тай хамтран сонгон шалгаруулж, 8 хүний бүрэлдэхүүнтэй болоод байна. Иргэн даатгуулагчийн төлөөллийг шалгаруулах нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан боловч ирүүлсэн материал тэнцээгүй байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 419 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцэж, ЭМДЕГ-	70

	нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна							тай гэрээ байгуулан санхүүжилт авч ажилласан. . Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч нарын цалинг 10,0%, эмнэлгийн тусгай мэргэжилтний цалинг 15%-иар нэмэгдүүлсэн. БОЭТ-ийн санхүүжилтээр 280.0 сая төгрөгөөр лабораторийн нэгдсэн тасаг, 194.0 сая төгрөгөөр амбулаторийн 3 давхарт засвар хийгдсэн.	
22	2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	3	Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ.	2022-2024	НБХ		Арга хэмжээний төлөвлөгөөт үйл ажиллагааны хэрэгжилт 50 хувь	Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 71 эмийн сан, 13 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажиллаж байгаагаас тайлант хугацаанд 5 эмийн сан шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, 11 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцлан, 4 эмийн санг 1-3 сарын хугацаатай түдгэлзүүлсэн. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 113 эм зүйч, 143 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 2.6 хувь, эм найруулагч 4.9 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 9 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50%-иар нэмэгдсэн байна. Эмийн чанар, эмийн гаж нөлөөний сургалтад 86 эрхлэгчийг хамруулж, “Антибиотик эмийг жороор олгоё” 3 сарын аянд 71 эмийн сан нэгдэн антибиотикийг 100 хувь жороор олгон, 111 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулан гарын авлагаар ханган, антибиотикийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөмжийг 2516 хүнд өгсөн байна. Зайлшгүй шаардлагатай эмийн 8-р жагсаалт дахь зохих эмийн хангамж эм ханган нийлүүлэх байгууллагуудад дунджаар 89 хувьтай болж, өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна.Тайлант хугацаанд эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 90.4 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.3 хувиар нэмэгдсэн байна	95,1

23			Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2024	НБХ		Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлтэй болно.	Эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн удирдамжит хяналтаар стандартын дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 95%, ашиглалт 85,2%, БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалт 90%, ашиглалт 92%, Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт тоног төхөөрөмжийн хангалт 88%, ашиглалт 90%, Эрдэнэт клиник, сувилалд 86%, ашиглалт 98%-тай байна. Аймгийн хэмжээнд БОЭТ, Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг,Талын булаг клиникт эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер үндсэн орон тоогоор ажиллаж байгаа бөгөөд гэрээний үндсэн дээр сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, хувийн хэвшлийн ортой клиник нийт 28 байгууллагын багаж тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг тогтмол хөтлөн, урсгал засварыг хуваарийн дагуу үнэлгээ хийлгэж ажилласан. Тайлант хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний дуудлага 1081 ирснээс дуудлагын дагуу хэвийн ажиллагаанд 418 эмнэлгийн тоног төхөөрөмжийг оруулсан ба сэлбэг хэрэгсэл олдохгүй, ашиглалтын хугацаа хэтэрч ашиглах боломжгүй болсон. эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо 21 байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээний сангийн программд 310 гаруй тоног төхөөрөмжийг бүртгэсэн байна.	100
24	2.1.9.Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж ,нийгмийн	1	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлнэ.	2021-2024	НБХ, ЭМГ		2 БОЭТ төгсөлтийн дараах сургалт явуулдаг болно.	Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараах сургалтад “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 2 резидент эмч суралцаж байна. Орон нутагт анх удаа эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн чиглэлээр сувилахуйн мэргэшүүлэх сургалт зохион байгуулах эрхийг 2022 онд авсан ба яаралтай тусламжийн сувилахуй 7, эрчимт эмчилгээний сувилахуй 1 тус тус суралцаж, нийт төгсөлтийн дараах	100

	хамгааллыг дэмжинэ.						сургалтад 10 эмч, сувилагч суралцсан байна.	
25		3	Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, ЭМГ	50 хүртэлх эмч, мэргэжилтэн ажиллан суралцсан байна.	Тайлант хугацаанд 2023-2024 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 98 эмч, 93 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн нийт 191 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаагаас төрийн сангийн санхүүжилтээр 26 эмч, 9 сувилагч, тусгай мэргэжилтэн, нийт 35 суралцаж байна. Үүнээс орон нутагт нэн шаардлагатай эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд мэс засал судлалаар 1 эмч, эх, ураг судлалаар 1 эмч, хэвлийн хөндийн хэт авиа оношилгоо судлалаар 1 эмч, арьс судлалаар 1 эмч төрийн сангийн санхүүжилтээр суралцаж байна. Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 36,3% байна. Төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад 9 эмч тайлант хугацаанд төгсөн ирж захиалагч байгууллагадаа ажилласан. Эрүүл мэндийн байгууллагын 12 ажилтныг ХАБЭА-н мэргэшүүлэх сургалт, давтан сургалтад хамруулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт томуу томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой өрхийн эрүүл мэндийн төвийн давхардсан тоогоор нийт 55 эмчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан. БОЭТ-ийн 29 эмч өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, ажил мэргэжлийн туршлага солилцох сургалтад хамрагдсан ба эрүүл мэндийн салбарын 17 сувилагчийг БНХАУ-ын Ордос, Хөх хот, БНСУ, Япон улсуудад богино хугацааны сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 72,4% ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдаж, төвийн болон	100

							орон нутагт зохион байгуулсан ажлын байран дээр дадлагажуулах 16 удаагийн сургалтад 238 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.		
26		5	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2023	НБХ	ОНТ 175.0 сая	<p>Тайлант хугацаанд “Эмч” хөтөлбөрийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 175.0 сая төгрөгийн төсвийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төгсөлтийн дараах сургалтад 112, ажлын байран дахь сургалтад 2221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. - “UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж нийт 35 эмч оролцлоо. - Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж нийт 30 илтгэл хэлэлцүүлэв. - Өндөр хөгжилтэй оронд нийт 40 эмч, мэргэжилтэн суралцаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр нийт 27 удаагийн соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан бөгөөд 594 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна. Тайлант хугацаанд 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. - Эрүүл мэндийн салбарын 40 наснаас дээш нийт 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулан 49 ажилтан өөрчлөлттэй гарсныг эмчлэн, эрүүлжүүлж байна. - Эрүүл мэндийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулагдсан 4 төрөлт спортын наадамд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын баг тамирчид амжилттай оролцон 2-р байр эзэллээ. <p>Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 7.9%, нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь</p>	Хөтөлбөрийн үйл ажиллагаа хэрэгжилт 40 хувь байна.	100

								24.4% -тай болсон ба тус хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна.	
27	2.1.12.Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	4	Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ	ОНТ 40.0 БОЭТ гүйцэтгэлийн санхүүжилт 647.6	Шаардлага хангасан байгууллагын тоо 75 болсон байна.	Тайлант хугацаанд: - Өрхийн 8 эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болж, ажиллах орчин нөхцөл 100 хувь хангагдан сайжирсан. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд Жаргалант сумын төсвөөс 20 сая төгрөг шийдвэрлэн стандартын дагуу болгож засварлах урсгал засвар хийгдсэн. - Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр шинэ өрхийн эрүүл мэндийн төв байгуулах хүсэлтийг Орхон аймгийн Засаг Даргад хүргүүлэн шинээр баригдаж буй Зэст багийн В1,1,2 давхрыг өрхийн эрүүл мэндийн төвийн зориулалт, стандартын дагуу засварлах шаардлагатай төсвийг төсвийн нэмэлт тодотголд оруулах саналыг хүргүүлсэн. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт орон нутгаас 20.0 сая төгрөг батлагдаж зураг бүрэн зурагдсан. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3, 4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн байгууллагын санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилга байгууламж 100% стандартын шаардлага хангасан.	100
28	2.1.13.Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой	2	Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээний багцыг оновчтой болгож,	2021-2024	НБХ	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлсэн байна	ЭМДҮЗ-ийн 2022 оны 05-р тогтоолын дагуу эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын санхүүжилтийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтоож нэг иргэний санхүүжилтийг нэвтрүүлсэн. Сум болон өрхийн эрүүл мэндийн төвүүд ЭМДЕГ-тай гэрээ	100	

	болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.		гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ.				байгуулан тусламж үйлчилгээг багцын дагуу иргэдэд үзүүлж байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний багцыг шинэчлэн тогтоох Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөлд санал хүргүүлсэн. Тайлант хугацаанд аймгийн хэмжээний нийт үзлэгийн 48.2 хувийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдэж, нэг эмчид ногдох үзлэгийн тоо 5401 буюу нэг өдөрт 246 хүн тусламж үйлчилгээ авсан үзүүлэлттэй байна. Эрүүл мэндийн даатгалын 1 иргэний санхүүжилтээр эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд 4.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт 4 тусламж үйлчилгээг 7418 иргэнд үзүүлснээс 1635 иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээ, 380 иргэнийг гэрийн эмчилгээнд, 757 иргэнийг өдрийн эмчилгээнд, 4401 иргэнд оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээг үзүүлж 245.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.	
29	3	Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно.	2021-2024	НБХ		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагаар үнэлгээ хийгдсэн байна	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх зорилгоор МАСАН-2 төсөлтэй хамтран Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулсан. Сум эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилт, хүний нөөц, үйлчлүүлэгчийн үнэлгээг www.1313.mn сайтаас харах боломж бүрдүүлж, нээлттэй, ил тод байдлыг хангасан. Түүнчлэн тус төслийн хүрээнд “Эрдэнэт хүмүүний эв нэгдэл” ТББ-тай хамтран Анхны-Оч, Мөнхсүндэрэл өрхийн эрүүл мэндийн төвд хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлж, үнэлгээний дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажилласан.	100
Хэрэгжилтийн дундаж хувь-90%								

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ